



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Авто тээврийн үндэсний төвийн Булган салбарын
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2024 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 279

танай _____ ны № _____ т

АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН БУЛГАН САЛБАРЫН ДАРГА
Н.БААСАНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Булган салбарын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Булган салбарын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зам, тээврийн хөгжлийн яамнаас салбарын хэмжээнд 2023 оныг бүрэн цахимжсан, бүтээмжийг дээдэлж, хариуцлага, үр дүнг тооцох жил болгон зарлаж, “түгжрэлгүй” түргэн шуурхай төрийн үйлчилгээг бий болгох зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тээврийн хэрэгслийн тоо өмнөх оноос нэмэгдсэнээс орлогын төлөвлөгөөг 31,411.7 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Техник хяналтын үзлэгт хамрагдаад тэнцээгүй автотээврийн хэрэгслийн хуримтлагдсан 11,892.2 мянган төгрөгийг урьдчилж орсон орлого дансаар бүртгэсэн байна.

000020648

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2022.12.31.	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	535,891.90	509,106.90
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	227,610.00	227,610.00
	Нийт хөрөнгийн дүн	763,501.90	736,716.90
	Нийт өр төлбөрийн дүн	10,457.59	11,525.53
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	767,010.02	744,772.37
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	777,467.61	756,297.90
Орлогын дэлгэрэнгүй тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	304,875.61	321,229.13
	Борлуулалтын өртөг	263,439.30	304,334.79
	Үйл ажиллагааны үр дүн	41,436.31	16,894.34
	Орлогын дүн	17,802.60	18,847.16
	Удирдлага, борлуулалтын зардлын дүн	28,195.04	47,633.67
	Үйл ажиллагааны нийт үр дүн	31,043.87	(11,892.2)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735,966.14	756,664.19
	Тайлант оны үр дүн	31,043.88	(11,892.2)
	Эцсийн үлдэгдэл	767,010.02	744,772.00
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	273,418.59
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	267,235.30
	Үйл ажиллагааны ЦМГ	-	6,183.29
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Зарлагын гүйцэтгэл	-	560,902.10
	Урсгал зардал	-	560,902.10
	Хөрөнгийн зардал	-	-
	Орлогын гүйцэтгэл	-	426,179.90
	Орлогын гүйцэтгэл	-	426,179.90
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,068.2 төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,068.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1 зөвлөмжийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,504.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага гараагүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд андуурсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй техникийн үзлэг болон оношилгооны орлого 1,068.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НБББББ-ийн 4.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх онуудын техник хяналтын үзлэгт хамрагдаад тэнцээгүй автотээврийн хэрэгслийн хуримтлагдсан төлбөрийг УОО дансанд бүртгэж байгааг нэг жил болсон тохиолдолд орлогоор хүлээн зөвшөөрч бууруулах ажлыг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулса н		Буруу тусган илэрхийлсэ н		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагү й			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга хийгдээгүй.												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Техник хяналтын үзлэгт хамрагдаад тэнцээгүй ТХ-ийн хуримтлагдсан төлбөрийг орлогоор хүлээн зөвшөөрч, УОО-ыг бууруулаагүй байна.	1	1,068.2					1	1,068.2				
Дүн	1	1,068.2					1	1,068.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	АТҮТ-ын Булган салбар	1	1			1			
	ТШЗ-ийн дүн	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			